



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 1/2017

Мандалговь

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтаар заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн 1-р дотуур байрны дээврийн засварын ажил /БСШУСЯ/2017/03008/ ажлыг ашиглалтад оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Эрдэнэ-Очир /Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн дарга/

Нарийн бичгийн дарга: О.Мөнхзул /Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн мэргэжилтэн/

Гишүүд:
Д.Нэргүй /ГХБХБГ-ын БХБХэлтсийн дарга/
Э.Энхмэнд /ГХБХБГ-ын БХБХэлтсийн мэргэжилтэн/
Я.Алтанхундага /Аймгийн ОБГ-ын дарга/
Б.Мягмарсүрэн /"Автор" ХХК-ний инженер/
Б.Насанжаргал /"ДӨЛ БГМ" ХХК-ний инженер/
Т.Туяамандах /Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн захирал/
П.Алтанчимэг /Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дарга/

Хоёр. Засвар шинэчлэлтийн ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, засварын ажлыг зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлтийг гарган, архивд хүлээлгэн өгч ажиллахыг комисс /Н.Эрдэнэ-Очир/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200798